

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

## “МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨХХК-Д

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хуралдааны 25 дугаар тэмдэглэлд:

“ХҮИИ.2. Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн хүрээнд Дорноговь аймгийн Сайншанд хотын нутаг дэвсгэрт барих орон сууцны хотхоны бүтээн байгуулалтын ажлын явцын талаар Батлан хамгаалахын сайд Н.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан Дорноговь аймгийн Сайншанд хотын нутаг дэвсгэрт барих “Газрын тосны үйлдвэрийн хотхон”-ны барилгын зураг төслийг хэсэгчлэн батлуулах, туслан гүйцэтгэгч байгууллагыг сонгон гэрээ байгуулж, хотхоны бүтээн байгуулалтын ажлыг шуурхай эхлүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг нарт даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР